

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ГОМДЛЫН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 06 дугаар сарын 19

Улаанбаатар хот

№	Өргөдөл, гомдлын системийн ангилал	Гомдлын агуулга	Гомдлын шалтгаан	Гомдлын шалтгаан тодруулах ангилал	Шалтгаан тодорхойлсон албан хаагчийн мэдээлэл	Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ
1	2	3	4	5	6	7
1	Согтууруулах ундааны зөвшөөрөл, худалдаа, үйлчилгээний тухай	Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо 21.2 байрны 2 давхарт 10 өрөөнд үйл ажиллагаа явуулж "Ану" дэн буудал нь, байгаа ба уг буудалд оюутнууд, эмэгтэйчүүд цагаар болон хоногоор бие үнэлдэг газар болсон бөгөөд уг буудлаас арьс өнгөний болон бэлгийн замын халдвар өвчин авсан тухай мэдээлэл удаа дараа гарч байна тухай.	Шөнийн цагаар буудалд архидан согтуурч мансууран гадаа гарч хэрэлдэж зодолдон амгалан тайван байдлыг алдагдуулах мөн арьс өнгөний, бэлгийн замын халдвар өвчин гарч байгаа тул дэн буудлын үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож зөрчлийн хуулиар торгох, арга хэмжээ авах.	Холбогдох хууль, журам, баримт бичиг	А.Норжин	1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/290 дүгээр "Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрэлдэхүүн баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам"-ын дагуу MNS5738:2007 дэн буудлын ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилтийг хангуулах. 2.Садар самуун явдалтай тэмцэх тухай, архи согтууруулах ундаа болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны талаар харъяа дүүргийн цагдаа, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах, шийдвэрлүүлэх. БЗДХ, ХДХВ, ДОХ-ын халдвараас урьдчилан

1	2	3	4	5	6	7
						сэргийлэх тухайн зочид буудал, дэн буудлуудад мэдээ мэдээллийг байршуулах.
	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	Баян-Өлгий аймаг дахь Тэнгэр транс ХХК-ий тээвэр зохицуулагч байна. 2 дугаар сард Нийслэлийн аялал жуулчлалын газраас Дөрвөдийн баярт ирэх хүмүүсийн авчраад өгөөч ээ, 14 хоногийн дотор төлбөрийг нь хийнэ гэж хэлсэн боловч одоог хүртэл мөнгөө өгөхгүй байна. Уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж, яаралтай шийдвэрлэж өгнө үү.	"Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2026 оны 03 дугаар сарын 7,8-ны өдрүүдэд зохион байгуулсан "Бүргэдийн баяр" арга хэмжээний зардал, тооцоог одоог хүртэл төлөөгүй.	Холбогдох хууль, журам, баримт бичиг	Д.Долгоржав	Тус байгууллага нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай байгуулсан гэрээний дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний А/93 дугаар тушаалын дагуу яамнаас зардлыг гаргахаар шийдвэрлэсэн тул манай газар хариуцахгүй болно.
	Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны тухай	Зардал мөнгөний асуудлын яаралтай шийдвэрлэж өгнө үү. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.	"Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2026 оны 03 дугаар сарын 7,8-ны өдрүүдэд зохион байгуулсан "Бүргэдийн баяр" арга хэмжээний зардал, тооцоог одоог хүртэл төлөөгүй.	Холбогдох хууль, журам, баримт бичиг	С.Туул	Тус байгууллага нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай байгуулсан гэрээний дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний А/93 дугаар тушаалын дагуу яамнаас зардлыг гаргахаар шийдвэрлэсэн тул манай газар хариуцахгүй болно.

1	2	3	4	5	6	7
	Урлаг соёлын арга хэмжээний тухай	Тэнгэр бөөгийн фестиваль нь маш муу зохион байгуулалт бол үнэхээр 0 байлаа. Хүн нь таксаа ав таксаа ав гээд л ёрөөсөө мөнгөний үйл ажиллагаа болсон юм шиг. Мөн тэнд очсон олон хүмүүс, жуулчид утсаа алдсан. Маш хариуцлаггүй хулгайч ихтэй ядаж хүмүүстээ сануулж болохгүй цагдаа нь ч тоож байгаа юм байхгүй байдалтай өнгөрлөө. Миний бие өчигдөр утсаа алдчихлаа. Үнэхээр зохион байгуулалт муутай мөнгөний арга хэмжээ зохион байгуулахаа болиочээ гэж хэлмээр байна. Уламжилж өгнө үү.	Тухай арга хэмжээнд оролцох гэж ирээд гар утсаа алдсан тул гомдолтой байна.	Холбогдох хууль, журам, баримт бичиг	Б.Энхцэцэг	Арга хэмжээний зохион байгуулж буй газраас Хэв журам хариуцсан цагдаагийн албан хаагчдад мэдээллийг үнэн бодиттой өгч Иргэд, жуулчдын гомдлыг цаг тухай бүрт шийдвэрлэж ажиллаж байх.

ХЯНАСАН: БОДЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

С.ТУУЛ

НЭГТГЭСЭН: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА, СУРГАЛТ СУДАЛГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.ЦОЛМОН



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн
хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

1.1.Нийслэлийн Аялал жуулчлалын газарт иргэн, аж ахуйн нэгж, албан хаагчдаас ирсэн өргөдлийг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн байдал, холбогдох байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид хариу өгсөн эсэх, холбогдох албан хаагчдад зөвлөмж өгөх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл

2.1.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын 1.2-т заасныг баримтлан 2026 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн өргөдлийн шийдвэрлэлт болон ажил хариуцсан албан хаагчийн тайлбар, холбогдох материалд үндэслэн хэрхэн шийдвэрлэсэн байдлын үр дүнд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

3.1.Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны II улирлын байдлаар нийт 11 өргөдөл, гомдол (www.erp.ulaanbaatar.mn)-д бүртгэгдсэн байна. Төрлөөр нь авч үзвэл:

- Байгууллагын албан хаагчдаас 6 өргөдөл, иргэнээс 4 гомдол, иргэнээс 1 хүсэлт ирсэн байна.

Иргэнээс ирсэн 2 гомдол байгууллагын үйл ажиллагаатай шууд хамааралгүй гомдол, хүсэлт байна. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайн хүсэлт, гомдолд чиг үүргийн хүрээнд шийдвэрлэж холбогдох байгууллагад уламжилж өгсөн байна. Иргэнд хариу, тайлбарыг тухай бүр өгсөн байна.

Өргөдлийг ангилан авч үзвэл:

№	Ангилал	Өргөдлийн тоо
1	2	3
1	Ажилд орох тухай	2
2	Жирэмсний амралтын тухай	1
3	Ажлаас чөлөөлөгдөх тухай	1
4	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	2

Байгууллагад нийт 2026 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар ирсэн өргөдөл гомдлыг 2025 оны II улирлын байдалтай харьцуулахад өргөдөл, гомдлын тоо 1-ээр өссөн байна.

Д/д	Үзүүлэлт	2025.01.01-06.05		2026.01.01-06.19	
		Тоо	Шийдвэрлэлтийн хувь	Тоо	Шийдвэрлэлтийн хувь
1	Ирсэн өргөдлийн тоо	10	100%	11	100%

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж


Нийт ирсэн 11 өргөдлийг 5 албан хаагч хугацаанд нь 100% шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 04 хоног 06 цаг 22 минут байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар улирал тутамд тайлан гаргаж, Газрын дарга болон Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргад танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй..

Дараах зөвлөмжийг албан хаагчдад хүргүүлж байна.

Үүнд:

- ✓ Цаашид өргөдөл хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлэхдээ зөрчил үүсгэхгүй байхад анхаарч, шуурхай шийдвэрлэн ажиллах;
- ✓ Өргөдөл, гомдлын улирлын тайланг байгууллагын цахим хуудаст улирал бүр байршуулан олон нийтэд мэдээлж ажиллах;
- ✓ Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хариу өгсөн хэлбэрийг тайланд тусгаж байх;

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА



Д.БАТСҮХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ч. Энх-Отгон Ч.ЭНХ-ОТГОН

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2026 оны II улирал)

2026 оны 06 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Тус газарт 2026 оны II улирлын байдлаар нийт 11 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байна. 2025 оны I улирлын байдалтай харьцуулахад өргөдөл, гомдол 1-ээр өссөн байна.

Үзүүлэлт	2025.01.01-06.05		2026.01.01-06.19	
	Тоо	Шийдвэрлэлтийн хувь	Тоо	Шийдвэрлэлтийн хувь
Ирсэн өргөдлийн тоо	10	100%	11	100%


Нийт ирсэн 11 өргөдлийг 5 албан хаагч хугацаанд нь 100% шийдвэрлэсэн. Газрын дарга болон Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргад өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар сар тутамд танилцуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Өргөдөл гомдлыг төрлөөр нь авч үзвэл:

- 1800-1200 дугаар-2,
- 11-11 төвөөс-2
- Цаасан хэлбэрээр хүсэлт-1,
- Жирэмсний амралтын тухай-1
- Ажилд орох тухай-2
- Ажлаас чөлөөлөгдөх тухай-1
- Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай-2 тус тус ирсэн байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 04 хоног 06 цаг 22 минут байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар газрын хурлаар нийт албан хаагчдад танилцуулж, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Үйлчилгээний Нэгдсэн төвд улирал бүр өргөдөл гомдлын тайланг хугацаанд нь хүргүүлж байна.

Өргөдөл, гомдлын дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

ТАНИЛЦСАН
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН,
ТОГТООЛ ШИЙДВЭР ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

Д.ДОЛГОРЖАВ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан
(2026 оны II улирал)

2026 оны 06 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Д/д	Хэнээс	Өргөдлийн утга	Шийдвэрлэлт	Шийдвэрлэсэн албан хаагч
1	2	3	4	6
1	Г.Алтанхуяг	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо Бүрд нэртэй зочид буудал ямар ч стандартгүй үйл ажиллагаа явуулж байна. Тус газрыг шалгаж өгнө үү.	Гольдрил ХХК-ийн Бүрд дэн буудлын гомдлын талаарх шалгалтыг Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо хариуцсан байцаагч Ц.Мөнхзул болон Хүнс худалдааны үйлчилгээний хэлтсийн М.Буянзаяатай хамтран 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Иймд тус зочид буудал нь ulaanbaatar.mn цахим бүртгэлийн системд бүртгэл үүсгээгүй баримт бичгийн баталгаажуулалт хийгдээгүй байна. Тухайн байгууллагад стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулах албан шаардлага хүргүүлсэн.	А.Норжин
2	Б.Жаргалан	Миний бие Баярмагнайн Жаргалан нь 2011 оноос хойш тус газарт Эвент хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан ба 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Хүүхэд асрах чөлөөтэй байсан. Миний хүү болох Б. Тогтуун нь 3 нас хүрч одоогоор хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусаж ажилдаа буцаж орох хүсэлтэй байгаа тул өргөдлийг шийдвэрлэж өгнө үү.	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн Б/09 дүгээр тушаалаар Б.Жаргаланг Эвент хариуцсан мэргэжилтнээр томилсон болно.	Ш.Ундармаа
3	Б.Жаргалан	Миний бие Б.Жаргалан нь 2011 оноос хойш тус газарт Эвент хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна. Б.Жаргалан нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газарт шилжин ажиллах хүсэлтэй байгаа тул хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү.	Эвент хариуцсан мэргэжилтэн Б.Жаргалан нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжин ажиллах хүсэлт гаргасан боловч АТГ-т ХАСХОМ-ийг хянуулахаар явуулсан, томилгоо хийдээгүй учраас цалингүй чөлөө олгох хүсэлтийг дахин гаргасан. Тиймээс Б.Жаргаланг газрын	Ш.Ундармаа

			даргын 2026 оны Б/10 тушаалаар 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд цалингүй чөлөө олгосон болно.	
4	Б.Энхмаа	<p>ну дэн буудал нь Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, 21.2 байрны 2 давхарт 10 өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа ба уг буудалд оюутнууд, эмэгтэйчүүд цагаар болон хоногоор бие үнэлдэг газар болсон бөгөөд уг буудлаас арьс өнгөний өвчин, ДОХ-ын халдвар авсан тухай байнга яригдах боллоо. Үүнд: 1.Ану дэн буудлыг шөнийн 2 цагт гэнэтийн шалгалт хийж үйлчлүүлэгчдийг ДОХ болон бэлгийн замын халдварт өвчний шинжилгээнд хамруулах шаардлагатай байна.2.Ану буудалд цагаар үйлчлүүлдэг байдлыг бүрэн хориглох.3.Шөнийн цагаар буудалд архидан согтуурч мансууран гадаа гарч хэрэлдэж зодолдон амгалан тайван байдлыг алдагдуулж байгаа тул дэн буудлын үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож зөрчлийн хуулиар торгож, арга хэмжээ авах шаардлагатай байна.</p>	<p>Өргөдөл гомдлын дагуу иргэнтэй холбогдож мэдээлэл авав. Мэдээллийн дагуу иргэнд 1.Садар самуун явдалтай тэмцэх тухай, архи согтууруулах ундаа болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны талаар харъяа дүүргийн цагдаагийн байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх боломжтой талаар мэдээллийг өгөв.2.Мөн манай байгууллагаас зочид буудал, дэн буудлын тусгай зөвшөөрөл олгодоггүй бөгөөд Ulaanbaatar.mn сайтад иргэн аж ахуйн нэгж байгууллага нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/290 дүгээр "Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрэлдэхүүн баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам"-ийн 5.1 дүгээр зүйл. Иргэн хуулийн этгээд худалдаа, үйлчилгээ эрхлэх тухай мэдэгдлийг дараах дарааллын дагуу хүргүүлснээр үйл ажиллагаа эрхлэх эрх үүсгэх гэсний дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн үйл ажиллагаа эрхэлж болно.3. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороонд байрлах Ану дэн</p>	А.Норжин

			буудалд 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран MNS5738:2007 дэн буудлын ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилтийг хангуулахаар болов.	
5	Б.Жаргалан	Миний бие Баярмагнайн Жаргалан нь 2011 оноос хойш тус газарт Эвент хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна. Б.Жаргалан нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газарт шилжин ажиллах хүсэлтэй байгаа тул хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/14 дугаар тушаалаар Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Эвент хариуцсан мэргэжилтэн Б.Жаргаланг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжүүлсэн болно.	Ш.Ундармаа
6	А.Норжин	Миний бие Амгаланбаатар овогтой Норжин нь Эвент хариуцсан мэргэжилтнээс 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс гарах болсон тул шийдвэрлэж өгнө үү.	А.Норжинг өөрийн хүсэлтийн дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар албан тушаалаас чөлөөлсөн.	Д.Долгоржав
7	Б.Энхцэцэг	Батдэлгэрийн Энхцэцэг миний бие 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэх "Хүүхэд асрах чөлөө" авсан. Хүү А. Дөлгөөнбилиг нь 9 сар хүрч байгаа тул хөдөлмөрийн тухай хуулийн 139.2 дахь заалтын хүрээд "Хүүхэд асрах чөлөө"-г 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөр дуусгаж, ажилдаа эргэн орох хүсэлтэй тул ажил албан тушаалд эргүүлэн томилж өгнө үү.Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 136.1.Амрах, хооллох завсарлагаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насныхар хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч	Б.Энхцэцэгийг өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 18-ны Б/22 дугаар тушаалаар ажилд томилсон.	Д.Долгоржав

		эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно. Ажилтны хүсэлтээр хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажлын цагийг богиносгох хэлбэрээр олгож болно. 136.2.Хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлагыг ажилласан цагт тооцож ажилтанд олговор олгоно. 140.1.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой харилцан тохиролцож болно.” дээрх боломжуудыг харгалзан үзэж уян хатан шийдвэрийг гаргаж өгнө үү.		
8	А.АЙДОС	Баян-Өлгий аймаг дахь Тэнгэр транс ХХК-ий тээвэр зохицуулагч байна. 2 дугаар сард Нийслэлийн аялал жуулчлалын газраас Дөрвөдийн баярт ирэх хүмүүсийн авчраад өгөөч ээ, 14 хоногийн дотор төлбөрийг нь хийнэ гэж хэлсэн боловч одоог хүртэл мөнгөө өгөхгүй байна. Уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж, яаралтай шийдвэрлэж өгнө үү.	Танай байгууллагын яамтай байгуулсан гэрээний дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний А/93 дугаар тушаалын батлагдсан төсвөөс тус яамнаас зардлыг гаргахаар шийдвэрлэсэн тул манай газар хариуцахгүй болно. Иргэнд 99515107 утсаар залган мэдээллийг хүргэсэн.	Д.Долгоржав
9	А.АЙДОС	Нийслэлийн Соёл, урлагийн газраас Улаанбаатар хотод 2 сарын5,6-нд зохион байгуулсан бүргэдийн баярын зардал, тооцоог одоог хүртэл төлөөгүй байгаа юм. Зардал мөнгөний асуудлын яаралтай шийдвэрлэж өгнө үү. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.	Танай байгууллагын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай байгуулсан гэрээний дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний А/93 дугаар тушаалын дагуу яамнаас зардлыг гаргахаар шийдвэрлэсэн тул манай газар хариуцахгүй болно. Иймд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд тухайн хүсэлтийг уламжлах тухай иргэнд	С.Туул

			99515107 утсаар залган мэдээллийг хүргэсэн.	
10	О.Хандам	О.Хандам (УЗ94032908) миний бие нь жирэмсний 32 долоо хоногтой болсон тул Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн жирэмсний болон амаржсаны амралтыг минь олгож өгөхийг хүсэж байна.	Газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Б/36 дугаар тушаалаар Мэдээллийн төвийн ажилтан О.Хандамд жирэмсний болон амаржсаны амралтыг олгов.	Ш.Ундармаа
11	Б.Түвшинтөгс	Тэнгэр бөөгийн фестиваль нь маш муу зохион байгуулалт бол үнэхээр 0 байлаа. Хүн нь таксаа ав таксаа ав гээд л ёрөөсөө мөнгөний үйл ажиллагаа болсон юм шиг. Мөн тэнд очсон олон хүмүүс, жуулчид утсаа алдсан. Маш хариуцлаггүй хулгайч ихтэй ядаж хүмүүстээ сануулж болохгүй цагдаа нь ч тоож байгаа юм байхгүй байдалтай өнгөрлөө. Миний бие өчигдөр утсаа алдчихлаа. Үнэхээр зохион байгуулалт муутай мөнгөний арга хэмжээ зохион байгуулахаа болиочээ гэж хэлмээр байна. Уламжилж өгнө үү.	иргэн Б.Түвшинтөгстэй 88031350 дугаартай утсаар ярьж, асуудлуудыг тодруулахад "Тэнгэр" олон улсын наадамд оролцож байхдаа утсаа алдсанаас үүдэн үйл ажиллагааг үзэх сонирхолгүй болсон. Хамгийн гомдолтой байгаа нь утсаа алдсан явдал юм. Цагдаа нарт хэлсэн боловч тоохгүй байсан. гэх мэдээлэл өгсөн. Иргэн Б.Түвшинтөгсийн асуудлаар Хан-Уул дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэст хандаж утасны марк бүртгэлийн дугаар мэдээллээ өгөхийг зөвлөсөн. мөн цагдаагаас тодруулж өгөхөөр болсон тул өргөдлийн хаав.	Б.Энхцэцэг

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ *Ш.Ундармаа*

Д.ДОЛГОРЖАВ